## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

### (2026 оны 1-р улирал )

### БАЙГУУЛЛАГЫН НЭР: УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

| | Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | МУ-ын хууль | | | | | |
| | 2 | 2 | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012-12-20 Дугаар 2012.12.20 | 7.2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална./7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ: 7.1.1.хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал;7.1.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал; 7.1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал. | Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамааран Хүнсний тухай хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврын дагуу GHP, GMP болон MNS CAC RCP 39:2011 стандартын шаардлагыг хангаж зохистой дадлыг мөрдөж ажиллаж байна.<br><br>1. Хүнсний түүхий эд, туслах материалын хяналт: Хүнсний түүхий эд, туслах материалыг боловсруулалтын шугаманд оруулахын өмнө ялган ангилж, гадны биет болон механик хольцоор бохирлогдсон, муудсан, мэдрэхүйн үзүүлэлт хангахгүй түүхий эдийг үйлдвэрлэлд хэрэглэхийг хориглон, нийлүүлэгчид буцаах, устгах арга хэмжээг авч ажилладаг.<br><br>2. Хоол үйлдвэрлэлийн боловсруулах технологи, шат дамжлага: Бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | түгээх зэрэг хүнсний үйлдвэрлэлийн бүх үе шатанд чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах зорилгоор хариуцсан баг, ажилтнууд хяналт тавин ажиллаж байна.<br><br>3. Бүртгэл, баталгаажуулалт: Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэрийн онцлогт тохируулан дараах бүртгэлүүдийг тогтмол хөтөлж байна. Үүнд:<br>● Ажилтны эрүүл мэнд, ариун цэврийн үзлэгийн бүртгэл<br>● Хөргөх төхөөрөмж, хөргөгчний температурын бүртгэл<br>● Их цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүртгэл<br>● Хүнс болон болсон хоолны дээжийн бүртгэл<br>● Хоол, хүнсэнд хийсэн температурын хяналтын бүртгэл<br>● Өдөрт бэлтгэсэн, олгосон хоол, хүнс, илүү гарсан болон устгасан хоол, хүнсний бүртгэл | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. Ажилтны хувийн ариун цэвэр, эрүүл мэнд: Ажилтнууд хувийн ариун цэвэр, гар угаах дэглэмийг мөрдөж, бээлий болон хамгаалах хувцсыг тогтмол хэрэглэн, эрүүл мэндийн урьдчилсан болон давтан үзлэгт хамрагдаж ажиллаж байна.<br><br>5.Бүтээгдэхүүнийг эргүүлэн татах, устгах: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзсэн тохиолдолд харьяалах хяналтын байгууллага, нийлүүлэгч болон дараагийн шатны үйл ажиллагаа эрхлэгчдэд утсаар, цахим шуудангаар мэдэгдэж, улмаар албан бичгээр мэдээлэн, хяналтын байгууллагын шийдвэрийн дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эргүүлэн татах арга хэмжээг авч ажилладаг. | |
| | | 3 | | 10.2. Энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /10.1.7.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, | Хоол үйлдвэрлэлийн ажиллагсад нь “Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим”-ын дагуу жилд хоёр удаа урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамрагдах шаардлагыг ханган ажиллаж байна.<br>Тус ажиллагсад зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн байгууллага болох **Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгт** урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах/; | хамрагдаж, холбогдох лабораторийн шинжилгээ болон эмчийн дүгнэлтээ авсан байна. | |
| | 3 | 4 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-08 Дугаар 2015.09.01 | 11.2. Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 7 дугаар зүйлийн 7.1, 9дүгээр зүйлийн 9.1, 9,3 дэх заалтын дагуу Жил бүр ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуульд заасан иж бүрдлээр бүрэн ханган, өвчтөн тээвэрлэх журмыг баримтлан ажиллаж байна. | 100 |
| | 4 | 5 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай 2016-04-22 Дугаар 2016.04.22 | 7.3. Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэхтэй холбогдох харилцааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна. | Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, ЭМС-ын 2025 оны А/111, 195, 242, 442 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| | 5 | 10 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 | 15.1.3. Нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах, мэдээллийн сан бүрдүүлэх; (15.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж, ажилтнуудын хүүхдэд зориулсан цэцэрлэг болон хүүхдийн эмнэлгийг харьяандаа ажиллуулж байна.<br><br>Мөн хүүхдийн яаралтай тусламжийн тусламж үйлчилгээний явцад хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдлыг эрт илрүүлэх, бүртгэх, холбогдох байгууллагад мэдээлэх чиглэлээр дотоод журам мөрдөн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилладаг. Үүнд, ийм төрлийн сэжигтэй тохиолдлыг илрүүлсэн даруйд цагдаагийн байгууллагад мэдэгдэх, тухайн ха<br><br>рьяа дүүрэг, хорооны нийгмийн ажилтантай шуурхай холбогдон хамтарч ажиллах зохицуулалтыг хэрэгжүүлж байна. | |
| | 6 | 11 | Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай 2017-05-12 Дугаар 2017.05.12 | 14.2.2.. Эх, нялх, балчир хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолтыг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, хэрэгжилтийг хангах; | Нялх, балчир хүүхдийн тухай хууль, байгууллагын дотоод журам холбогдох тушаал шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд эмчилгээний хоол зүйн тусламж үйлчилгээг стандартын дагуу зохион байгуулж байна.<br><br>1. Эмчилгээний хоолны хорооны үйл ажиллагаа<br>Байгууллагын Эмчилгээний хоолны хороо нь батлагдсан удирдамж, журамд нийлүүлэн дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна:<br>● Эмнэлгийн эмчилгээний хоолны нэр төрөл, жор, технологийг батлах, шинэчлэх<br>● Тусгай хэрэгцээт өвчтөний хооллолтыг зохицуулах<br>● Хоол үйлдвэрлэл түгээлтэд хяналт тавих, чанар, аюулгүй байдлыг үнэлэх<br>● Хоолны эмчилгээний үр дүнд хяналт шинжилгээ хийх зөвлөмж гаргах<br>● Хорооны хурлыг улирал бүр зохион байгуулж, шийдвэрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжилтийг хангах<br>2. Хэвтэн эмчлүүлэгчийн сахиур, эргэлтийн журам<br><br>Ерөнхий захирлын 2026 оны 01 дугаар сарын 14-ний өдрийн А/004 дугаар тушаалын дагуу “Хэвтэн эмчлүүлэгчдийн сахиур болон эргэлтийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтийн хүрээнд:<br><br>● Халдвар хамгаалал, хүнсний аюулгүй байдлын шаардлагыг мөрдүүлэх<br>● Зохисгүй, хориглосон хүнсний бүтээгдэхүүн нэвтрүүлэхээс сэргийлэх<br><br>3. А/440 тоот тушаалын хэрэгжилт<br><br>Тус тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор:<br><br>● Эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартыг мөрдөж эмчилгээний хоолны зохион байгуулалтыг сайжруулах<br>● Хоол зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх<br>● Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ● Хоол зүйч, холбогдох ажилтнуудыг сургалтад хамруулж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж байна | |
| | 8 | 15 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн албаны тухай хуульд заасан хууль журмийн дагуу ажилтан албан хаагчдыг тасралтгүй сургалтад хамруулах, Төрийн албаны тухай хуулийн 57 зүйлийн 57.1, 57.2, 59 дүгээр зүйлийн 59.1, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн дагуу Төрийн үйлчилгээний албан хаагчдын нийгмийн баталгааг ханган ажиллаж байна. | |
| | 9 | 16 | Донорын тухай /Шинэчилсэн найруулга/ 2018-01-19 Дугаар 2018.01.19 | 11.3.. Донорын цус, цусан бүтээгдэхүүн болон донорын эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний үнийн жишгийг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн гаргасан үнийн дагуу, төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийх хуулийг баримтлан цус, цусан бүтээгдэхүүн худалдан авч хэрэглэдэг | 100 |
| | | 18 | Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 50-р зүйл, ЭМС-н | 22.1.. Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа | Эмнэлгийн тусламж үйлчилгээг Донорын холбоотой байгуулсан хамтын ажиллагааны бичгийн дагуу | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2023 оны 6 сарын 14-ний А/211 тоот тушаал | эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, цусаа 35-аас дээш удаа өгсөн донорыг магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хүндэт доноруудад үзүүлдэг. Мөн ЦССҮТ-ийн хүсэлтийн дагуу зарим донорт лавлагаа шатны ахисан тусламж үйлчилгээг тогтмол үзүүлж байна. | |
| | | 43 | | 9.3.. Энэ хуулийн 7.1.15-д заасан нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, тоног төхөөрөмж ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. /Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | ЭМС-н 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/211 тоот тушаалын дагуу нөөцийг 3-аас доошгүй сараар бүрдүүлж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын захиралд үүрэг болгосон бөгөөд тус тушаал өнөөдрийг хүртэл хүчинтэй хэвээр байна. Өнөөдрийн байдлаар уг тушаалын хоёрдугаар хавсралтад заасан Эм - 81%, Нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл- 75,6%, Хувийн хамгаалах хэрэгсэл- 45,4%,. | 100 |
| | | | ЭМС-ын сайдын 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/173-р тушаалын хэрэгжилтинй хангах | Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах зааврыг нэгдүгээр, Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх зааврыг хоёрдугаар, Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай | ЭМС-ын 2025 оны А/173 тоот тушаалын дагуу 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нийт 12,937 кг аюултай хог хаягдлыг цуглуулсан байна. Үүнээс халдвартай хог хаягдал-12,474 кг, хурц үзүүртэй, иртэй хог хаягдал-423 кг, эмгэг хог хаягдал-40 кг байна. Эдгээр хог хаягдлыг Элемент ХХК-тай байгуулсан гэрээний дагуу устгах үйл ажиллагаа явуулж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | 46 | | 13.3.. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ. | Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан мөрдлөг болгон ажиллаж байна. | 100 |
| 15 | 48 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан байгууллагын эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө зэргийг боловсруулан ажиллаж байна.<br>1. Байгууллагын эрхэм зорилго: Монгол улсын иргэдийн эрүүл амьдрах, сэтгэл ханамжийг хангаж ажиллах, үйлчлүүлэгч болон ажилчдын орчны аюулгүй байдлыг хангасан, үйлчлүүлэгч төвтэй цогц үйлчилгээг үзүүлэхийг зорин ажиллаж байна.<br>2. А. Үйл ажиллагааны стратегийн зорилго: Олон улсын стандартад нийцсэн, хүлээн зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээтэй холбоотой стандартуудыг нэвтрүүлж хэрэгжүүлсэн батламж авч, Монгол улсын шилдэг эмнэлэг болох, үйлчлүүлэгчдэд Монгол улсын шилдэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага гэдгээ хүлээн зөвшөөрүүлэх зорилготойгоор ажиллаж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Б. Үйл ажиллагааны стратегийн зорилт: Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь олон улсын магадлан итгэмжлэгдсэн байгууллага болох(JCI), гадаадаас үйлчлүүлэгч хүлээн авах, эмнэлгийн гол үйлчилгээг хөгжүүлэх, шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, эмнэлгийн ажилчдыг олон улсын жишигт нийцүүлэн сургах, мэргэшүүлэх, шаардлага хангасан эмнэлгийн орчин нөхцлийг бүрдүүлэх гэсэн 6 гол зорилт тавин ажиллаж байна.<br>3. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ба түүний үр дүн:<br>Байгууллагын өнөөгийн тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийснээр, эмнэлгийн цаашдын үр өгөөжтэй ажиллах, байгууллагын хөгжлийн бодлогын хүрээнд шинээр ямар арга хэмжээ, бодлого хэрэгжүүлэх тухай төлөвлөгөө гарган ажилласан.<br>Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийснээр Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн эрхлэх асуудал нь нийт 61 хууль байна. Үүнээс Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн эрхлэх асуудлын хүрээнд шууд хамаарах 18 хуулийн хүрээнд салбарын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон.<br>SWOT шинжилгээ хийж, дотоод орчны давуу болон сул тал, гадаад орчны эрсдэл, боломжийг дүгнэн шинжилж цаашид хэрэгжүүлэх эрсдэл | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | боломжийн төлөвлөгөөг нарийвчлан тодорхойлсон.<br>Салбар хоорондын хөгжлийн харилцан уялдаа, бодлого үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах арга замыг тодорхойлж, хүрэх үр дүнг тооцсон бөгөөд зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж цаашдын стратеги төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | |
| | 49 | | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн цахим хуудас болох http://ssch.gov.mn веб сайтын ил тод байдлын цэс нь:<br>● Үйл ажиллагааны ил тод байдал<br>● Төсөв санхүүгийн ил тод байдал<br>● Төлбөр тооцоо<br>● Худалдан авах ажиллагааны ил тод байдал<br>● Хүний нөөцийн ил тод байдал<br>● Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо<br>● Авлигын эсрэг үйл ажиллагаа гэсэн дэд цэснээс бүрдэх бөгөөд эмнэлгийн ерөнхий захирлын тушаалууд, үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө, төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээллүүд, нээлттэй ажлын байрны зар, шаардлагатай утасны жагсаалтуудыг байрлуулан тогтмол шинэчилдэг. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Мөн Улсын хоёрдугаар төв эмнэлэг facebook пэйж хуудас, өдөр тутмын үйл ажиллагаа, шинэ мэдээлэл, ажлын байрны зар гэх мэтчилэн байгууллагатай холбоотой мэдээллүүд 24 цаг тутамд шинэчлэгдэн орж байдаг. Түүнчлэн 70150222 гэсэн лавлах утас болон 70150235, эрүүл мэндийн даатгалын 70150211 утсуудаар эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой чанар, аюулгүй байдал, гомдол, санал хүсэлт, талархлыг хүлээн авч, бүх мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>Санхүү төсвийн тухай хуулийн дагуу https://shilendans.gov.mn/ сайтын Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хуудсанд мэдээллүүдийг тухай бүрд нь оруулж ажилладаг. | |
| | 50 | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Сар бүр шилэн дансны хуулийн дагуу ил тод болгох мэдээллийг хуулийн хугацаанд цахим системд байршуулсан. | 100 |
| | 51 | | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн эмнэлгийн дотоод хэм хэмжээг батлан гаргах шаардлагатай тул эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/28 дугаар тушаалаар байгууллагын “Мэдээллийн ил тод байдлыг хангах журам”, “Байгууллагын ил тод мэдээлэх мэдээлэл, түүнийг хариуцах нэгж, албан тушаалтны жагсаалт”-ыг баталсан. Байгууллагын ил тод | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | байдлын 2025 оны тайланг жилээр гарган ЭМЯ-нд хүргүүлсэн. | |
| | 52 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр”- ийн биелэлтийг 2025 оны жилийн байдлаар хийсэн.<br>Үүнд:<br>1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт<br>2.Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт<br>3.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт<br>4.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт<br>5.Хэрэглэгчийн үнэлгээ<br>6.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт<br><br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг ханган байна. | 100 |
| | 53 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | 1995-2021 онд батлагдсан хүчин төгөлдөр 43 хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 28 тогтоол, Эрүүл мэндийн сайд болон ТЕГ-ын дэд дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, генералтай хамтарсан тушаал, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2002 оны 122-р тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хамтарсан 2017 оны А/94, А/193-р тушаал, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2019 оны А/142, А/47-р тушаал, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 116/А565-р тушаал, Эрүүл мэндийн сайд, ХХААХҮС-ын 2022 оны хамтарсан А/255 А/137 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49/118 дугаар тушаал зэрэг хамтарсан 7 тушаал, Эрүүл мэндийн сайдын 127 тушаал, холбогдох дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | |
| | 54 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ssch.gov.mn домэйн хаягтай цахим хуудасны Танилцуулга хэсэгт бүтэц зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг зэрэг мэдээллүүд нийтлэгдсэн. | 100 |
| | 55 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | ЭМТҮЧАБ-ын албанд нийт 25 өргөдөл гомдол, санал хүсэлт бүртгэгдсэн байна. Талархал нийт-14 бүртгэгдсэн байна.<br><br>Үүнээс:<br><br>· Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой-18 буюу 72%,<br>· Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлагатай холбоотой-5 буюу 20%, | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | · Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой-15 буюу 53.5%,<br><br>· Бусад-2 буюу 8% байна.<br><br>Гомдлын төрлөөр нь:<br><br>· Гомдол-24 буюу 96%<br><br>· Мэдэгдэл (Хүсэлт)-1 буюу 4%Нийт ирсэн өргөдөл гомдлын бичгээр-2, утсаар хандсан-1, 1111 төв-21, албан бичгээр-1 байна.<br><br>Шийдвэрлэлт 100%. | |
| | 56 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/279 тоот тушаалын дагуу албаны нууцын жагсаалт, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн эрүүл мэндийн мэдээлэлд хамаарахгүй хэсгийг ЭМХТ-д тогтмол гаргаж өгч, эмнэлгийн цахим хуудсаар ил тод байршуулдаг. | 100 |
| | 57 | | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд болон олон нийтийн арга хэмжээ бүх төрлийн нээлттэй хөтөлбөр, зөвлөгөө мэдээлэл зэргийг тухай бүрт нь эмнэлгийн цахим хуудсаар болон фейсбүүк пейж хуудсаар зураг, ведио шторк, рийл, лайв, постер зэрэг төрлүүдээр баяжуулан иргэд олон | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | нийтэд мэдээллэн ажиллаж байна. www.ssch.gov.mn | |
| | 58 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/31 дугаар Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулах журмын дагуу ажлын байрны сонгон шалгаруулалтыг эмнэлгийн цахим хаягуудад нээлттэй мэдээлэн Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр сонгон шалгаруулж байна. | 100 |
| | 59 | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам” шинэчлэн батлаж, мөрдөн ажиллаж байна. Журмыг эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд нийтэд ил тод байршуулсан. | 100 |
| | 60 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/406 дүгээр “ эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлбах тухай” хууль, 2025 оны 05 дугаар сарын 01-нйи өдрийн А/174 дугаар тушаалыг хэрэгжүүлдэг. | 100 |
| | 61 | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Эмнэлгийн албан ёсны цахим хуудасны (www.ssch.gov.mn) “Ил тод байдал” хэсгийн “Хүний нөөцийн ил тод байдал хэсэгт Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж (хуульчилсан акт) дүрэм, журам, | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | заавар жагсаалт, байгууллагын ил тод байдлын тайланг байршуулсан. | |
| | 62 | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, журмын дагуу Хүний нөөцийн удирдлагын ил тод мэдээллийг эмнэлгийн цахим хуудас, shilen.gov.mn сайтад ил тод байршуулдаг. | 100 |
| | 63 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Эмнэлгийн алба, төв, тасаг, хэсгийн дарга, эрхлэгчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх нэгдсэн аргачлалаар хангах, удирдах албан тушаалтны ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор “Эмнэлзүйн төв, алба, тасгийн дарга, эрхлэгч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”, “Дэмжих алба, тасгийн эрхлэгч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг тус тус баталж, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна. | 100 |
| | 64 | | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | 2025 оны төсвийн гүйцэтгэл 52.107.193,2 мян.төг буюу 92%-ийн гүйцэтгэлтэй гарсан. 2026 оны төсөв 53.885.675,9 мян.төг, | 100 |
| | 65 | | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | 2026 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 12.333.636,3 мян.төг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.423. 316,7 мян.төг,туслах үйл ажиллагааны орлогоос 707.630,1 мян.төг нийт | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 14.464.583,1 мян.төг орлого төвлөрүүлэхээс 9.739.185,8 мян.төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Зардал 14.399.085,3 мян.төг зарцуулах эрхээс 9.635.101,4 мян.төг зардал гарсан байна. | |
| | 66 | | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын шалгалтаар тус эмнэлэг нь хязгааралттай дүгнэлт авсан. | 100 |
| | 67 | | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | 2026 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 12.333.636,3 мян.төг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.423. 316,7 мян.төг,туслах үйл ажиллагааны орлогоос 707.630,1 мян.төг нийт 14.464.583,1 мян.төг орлого төвлөрүүлж ажиллана. | 100 |
| | 69 | | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | 88 бэлтгэн нийлүүлэгчид нийт 3.638.612,7 мян.төг санхүүжилтээр бараа, ажил үйлчилгээ авсан. | 100 |
| | 72 | | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Эмнэлгийн албан ёсны цахим хуудасны (www.ssch.gov.mn) "Ил тод байдал" хэсгийн "Санхүүгийн ил тод байдал хэсэгт Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж /хуульчилсан акт/ дүрэм, журам, заавар жагсаалт, байгууллагын ил тод байдлын тайланг байршуулан ажиллаж байна.<br><br>Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу шилэн дансны мэдээллийг шинэчилсэн. Шилэн дансанд эхний улирлын байдлаар 30 мэдэлэл оруулахаас 24 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хугацаанд нь оруулж 6 мэдээлэл хугацаа хэтэрсэн байна | |
| | 73 | | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг тухай бүр шилэн данс болон tender.gov.mn цахим системд хууль тогтоомж журмын дагуу нийтэлсэн | 100 |
| | 74 | | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | Худалдан авах ажиллагааны үнэлгээний шатанд гарсан дүгнэлт нь тендер шалгаруулалт хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэхийг тодорхойлдог. Тендерийн үнэлгээний дүгнэлт нь Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр “хамгийн сайн үнэлэгдсэн тендер эсвэл татгалзсан шалтгаан” энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-д заасан журмыг баримтлан ажилласан. Шалгуур үзүүлэлт нь Техникийн тодорхойлолтын дагуу хийгдсэн. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан төсөвт багтаан, Тендерийн урилга, үр | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дүнг www.tender.gov.mn системд хугацаанд нь ил тод байдлаар мэдээлэн, гэрээний явц, санхүүжилт болон гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг анхааран ажилласан. Үнэлгээний хорооны гишүүдийн хараат бус байдал алдагдсан эсвэл тендерийн баримт бичгийг тодорхой нэг этгээдэд зориулж бэлдсэн эсэхэд хяналт шалгалт хийн хяналт шалгалтын тайлан нь зөвхөн алдаа дутагдлыг илрүүлэх бус, цаашид худалдан авах ажиллагааг сайжруулах зөвлөмж хэлбэртэй байх нь чухал юм. | |
| | 75 | | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсөвтэй уялдуулан боловсруулах, цахим системд баталгаажуулах зааварчилгаа, тендерийн баримт бичиг боловсруулахдаа техникийн тодорхойлолтыг өрсөлдөөнийг хязгаарлахгүйгээр тогтоох аргачлал, үнэлгээний шатны арга зүй, Үнэлгээний хорооны гишүүдийн ажиллах журам, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдэгдэл гаргах заавар, тендерт оролцогчийн ирүүлсэн материалыг магадлах, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд гардаг нийтлэг алдааг засварлах зөвлөмж, цахим системийн ашиглалт www.tender.gov.mn системд тендерийн урилга нийтлэх, тодруулгад хариу өгөх, үнэлгээний дүнг байршуулах технологийн зааварчилгаа, илэрсэн | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | нийтлэг асуудал ба авсан арга хэмжээ, зөвлөгөө өгөх явцад захиалагч талуудад дараах нийтлэг хүндрэлүүд байсныг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг заан ажилласан Үүнд: Тендерийн үнэлгээний хугацаа хэтрэх: Хуулийн хугацаанд багтаж шийдвэр гаргах төлөвлөгөөг гаргаж өгсөн. Магадлал шалгах ажиллагаа: Оролцогчдын ирүүлсэн туршлагыг хэрхэн бодитоор баталгаажуулах талаар арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан. | |
| | 76 | | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Төсөл хөтөлбөр байхгүй | 100 |
| | 77 | | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | Эмнэлгийн захиалгаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажил байхгүй.<br>. | 100 |
| | 78 | | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | https://tender.gov.mn/ болон https://shilendans.gov.mn/organization/4971?ry=2025&group=117<br>цахим системүүдэд “Шилэн дансны тухай Хуулийн дагуу сар, улирал, жилээр мэдээллийг шинэчлэн оруулж байгаа. | 100 |
| | 79 | | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | https://shilendans.gov.mn/organization/4971?ry=2025&group=117<br>Улсын хоёрдугаар төв эмнэлэг Төрийн сан 100900020006 тоот данс | 100 |
| | 82 | | 8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | ● Дүрс оношилгооны төвийн зөвлөх эмч Б.Эрдэнэбулган Монгол Улсын | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №14296 дугаар бүхий гэрчилгээг “Хөхний хэт авиан оношилгоо” номын бүтээлээр оюуны өмчийн эрх авсан.<br>● Нүд судлалын тасгийн эрхлэгч Д.Батжаргал Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №15155 дугаар бүхий гэрчилгээг “Монгол улсад эрүүл мэндийн аялал жуулчлал эрхлэх гарын авлага (нүдний тусламж үйлчилгээ)”, №15154 дугаар бүхий гэрчилгээг “Нүд харааны эрүүл мэндийн явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх төслийн гарын авлага” зэрэг бүтээлүүдээр оюуны өмчийн эрх авсан.<br>● Цөмийн оношилгоо эмчилгээний төв нь Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №0023243 “[18F] Натрийн фторид радио идэвхт эм”-ийг оюуны өмчийн эрхтэйгээр үйлдвэрлэж байна.<br>● Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгийн эмч Б.Нямжав нар нь Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №14953 “Чихрийн шижин хэвшинж 2-той хүмүүст ABCC8 генийн RS1799854, RS1801261 полиморфизмыг бодисийн солилцооны зарим үзүүлэлтүүдтэй холбон судалсан нь” бүтээлээр оюуны өмчийн эрх авсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ● Бөөр, дотоод шүүрэл судлалын тасгийн эрхлэгч С.Байгалмаа, эмч Б.Жанибек, эмч Э.Нарнызгэрэл нар нь Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №14422 “Бөөрний түүдгэнцэрийн өвчтэй хүмүүст бөөрний эдийн шинжилгээг дүгнэн, ANTIPLA2R эсрэг биеийг мембраноз нефропатийн оношилгоонд нэвтрүүлсэн байдлыг судлах” бүтээлээр оюуны өмчийн эрх авсан.<br>● Зүрх судас судлалын тасгийн Шигдээсийн нэгжийн эмч Л.Эрдэнэхүү, эмч Д.Амарзул нар нь Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №14940 “УХТЭ-т Пейсмекер суулгах эмчилгээ эхлүүлсэн туршлага” бүтээлээр оюуны өмчийн эрх авсан. | |
| | 84 | | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн өмчлөх эрх бүхий газрын хэмжээ-46433м2<br>Эмнэлгийн харъяа “Нар хайрхан” сувилалын газрын хэмжээ-3 га<br>Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь НЗДаргын 2022.01.11-ний өдрийн А/15 тоот захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн 20-р хороонд нэгж талбарын 1333018412 дугаар бүхий 35906 м.кв газрыг рашаан сувиллын зориулалтаар 40 жилийн хугацаатай эзэмших эрхийн улсын бүртгэлийн Э-2204022178 дугаар бүртгүүлж, №00000344477 тоот цахим гэрчилгээ авсан болно. Газрыг 2018.12.31-нээр 1,504,925,260.00 төгрөгөөр | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | санхүүгийн бүртгэлд бүртгэсэн болно. | |
| | | | | | |
| | 85 | | 8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | Улсын хоёрдугаар төв эмнэлэг<br>РД:9077146<br>Төрийн сан<br>100900020006 | 100 |
| | 86 | | 8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам"-ыг эмнэлгийн Ерөнхий захирлын 2025 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар шинэчлэн батлаж, мөрдөн ажиллаж байна. Журмыг эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд нийтэд ил тод байршуулсан. | 100 |
| | 87 | | 8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | 11 байгууллагад түрээсийн үйлчилгээ үзүүлэн 2026 онд…...... сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. үүнээс …............. сая төгрөгийг ТӨБЗГ-д төвлөрүүлсэн байна. | 100 |
| | 90 | | 8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | www.ssch.gov.mn цахим хуудсанд хязгаарлагдаагүй бүх төрлийн нээлттэй мэдээллийг иргэдэд зориулж тухай бүрт нь шинэчлэн байршуулагдан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | УИХ-ын тогтоол | | | | | |
| | 18 | 99 | Монгол Улс дахь хүний эрх, | 1.4/б/. эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй х | хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе шаттайгаар зохион байгуулах; | иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийг баритлан эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байраар ханган, сургалт сурталчилгааг үе шаттай зохион байгуулдаг. | |
| | | 100 | олбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62 | 1.4/в/. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах; | Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг нь иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээллийг хүртээмжтэй хүргэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна. Мөн тусгай хэрэгцээгт иргэдэд ЭМД-ын сангийн хөнгөлөлтөөр тусламж үйлчилгээг аль болох чирэгдэл, хүндрэл учруулахгүйгээр үзүүлэхийг зорьж ажиллаж байна.<br><br>Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг иргэн төвтэй, хүртээмжтэй үйлчилгээний зарчмыг баримтлан ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг өгөх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч байна. Цаашид нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн орчин, хэрэглэгдэхүүний хангалтыг сайжруулах, стандарт, удирдамжийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дагуу туслаж үйлчилгээг тасралтгүй явууллаж байна. | |
| | | 101 | | 1.4/г/. эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа дүрэм, журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, конвенцид заасан зохицуулалттай нийцүүлэх. | Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн хэмжээнд мөрдөгдөж буй дотоод журам, үйлчилгээний стандарт, үйл ажиллагааны зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахтай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтыг мөрдөн ажиллаж байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хуульд заасан нөхцөлөөр үнэ төлбөргүй авах боломжийг бүрдүүлэх зэрэг зохицуулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлж байна. | 100 |
| | | 107 | | 2.7/. Иргэд, олон нийтэд хувийн ариун цэврийг сахиж, хариуцлагатай байх, бусдын эрхийг хүндэтгэх талаарх мэдээлэл, сурталчилгааг идэвхжүүлэх; | Иргэд, олон нийтэд хувийн ариун цэврийг сахих, хариуцлагатай зан үйл төлөвшүүлэх, бусдын эрхийг хүндэтгэх талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор Улсын хоёрдугаар төв эмнэлэг-ийн цахим хуудсаар дамжуулан эрүүл зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлийн мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж байна. Мөн Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв болон Эрүүл мэндийн яам-наас бэлтгэн гаргадаг цаг үеийн зөвлөмж, сэрэмжлүүлгийг олон нийтэд тухай бүр түгээн ажиллаж байна.<br><br>2026 оны эхний улирлын байдлаар нийт 12 төрлийн 35 гаруй агуулга бүхий эрүүл | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
